

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Лааганжавын Дашдорж	Дугаар	L257
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Алтанбулаг сум
Төрсөн газар	Алтанбулаг сум	Төрсөн он	1918
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Улаанбаатар хотын Зүүн хүрээ, Баяртын жас, Бор-Өндөрийн жас	Сүм хийдийн дугаар	УБ 942, ТӨАБ 017, ТӨАБ 019, ТӨАБ 021
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-рсарын 11	Ярилцлага авсан хүн	Жужа, Энхбаяр



Улаанбаатар хотын Зүүн хүрээ, Төв аймгийн Алтанбулаг сумын Баяртын жас, Бор-Өндөрийн жас
 Жужа: Тэр бага байхдаа лам байсан уу?
 Дашдорж: Найман наснаасаа 19 хүртлээ.
 Жужа: Аль хийдэд шавилан сууж байсан бэ?
 Дашдорж: УБ хот, Зүүн хүрээнд байсан.
 Жужа: Аль аймагт нь?
 Дашдорж: Баргын аймагт.
 Жужа: Дуган нь гэр хэлбэртэй байсан уу, модон дуган байсан уу?
 Дашдорж: Модон дуган.
 Жужа: Гэр хэлбэртэй юу, дөрвөлжин үү?
 Дашдорж: Дээрээ ганжиртай.
 Жужа: Гол сахиус шүтээн нь юу байсан бэ?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

1

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Дашдорж: Тэр гомбо сахиустай, гомбо гэж бурхан байсан.

Жужа: Гирнаа гомбо байсан юм уу, зүгээр гомбо байсан юм уу?

Дашдорж: Гомбо, махгал.

Жужа: Баргын аймагт хэдэн лам сууж байсан бэ?

Дашдорж: 500 лам.

Жужа: Анх лам болоод хаана лам болсон бэ, энэ нутагт уу, Богдын хүрээнд үү?

Дашдорж: Богдын хүрээнд, 8-19 нас хүртлээ суусан. Одоогийн энэ циркийн хавьд байсан ш дээ, Баргын аймаг чинь.

Жужа: Дацан суудаг байсан уу?

Дашдорж: Эмчийн дацан байсан, өөрөөр хэлбэл мамба дацан гэж байсан.

Жужа: Мамба дацанд хэдэн лам хурдаг байсан юм?

Дашдорж: Хүрээ 30 аймгаас л лам нар сууж байсан шүү дээ, ямар ч байсан 50, 60 хүн байсан байлгүй.

Жужа: Мамбын дацангийн хажууд ямар дацан байсан бэ?

Дашдорж: Зурхай гэж байсан, Жүд дацан, зурхай дацан гэж.

Жужа: Мамба дацангийн гол шүтээн сахиус ямар сахиус байсан бэ?

Дашдорж: Дамдин, Манал хоёр.

Жужа: Өдөр болгон хуралтай байсан уу, эмчийн дацан?

Дашдорж: Жасаа хурал хурдаг байсан.

Жужа: Цагийн хурлууд ямар ямар хурал байсан бэ, сарын дүйчэн өдрөөр?

Дашдорж: Манал уншдаг.

Жужа: Өөр дүйчэн өдөр байсан уу, шинийн найман, арван таван, хорин хоёрноор ямар ямар хурал хурдаг вэ?

Дашдорж: Тэр дацангийн сахиус Дамдин гэж бурхан шүтдэг байсан юм.

Жужа: Маарамба хүн байсан уу?

Дашдорж: Олон лам нар байсан, эмч нар л байхгүй юу. Эм барьдаг.

Жужа: Хэдэн гэсгүй хэдэн унзад байсан бэ?

Дашдорж: 2 гэсгүй, 2 унзад байсан.

Жужа: Унзад гэсгүй нь ямар хүн байсан бэ, санаж байна уу?

Дашдорж: Гэсгүй нь Балдорж гэж хүн байсан. Унзад нь Дашдаваа гэдэг хүн байсан. Тэгээд солигдоод байдаг юм.

Жужа: Дацангийн толгойлох лам нь ямар цол хэргэмтэй байсан?

Дашдорж: Жинхэнэ энийг л төгссөн тийм хүн маарамба болно шүү дээ, эм барьдаг толгойлох...

Жужа: Мамба дацан хэдэн онд хаагдсан бэ?

Дашдорж: Нэлээн дээр л хаагдаж байсан. Нэг ёсондоо гучин долоон он хавьд хаагдсан байх аа.

Жужа: Энэ Баяртын жас хэдэн ламтай, хэдэн дугантай байсан юм?

Дашдорж: Хоёр жижиг модон дуган байсан. 20, 30-аад л лам байсан.

Жужа: Толгойлох лам нь хэн гэж байсан бэ?

Дашдорж: Уртнасан аграмба гэж байсан.

Жужа: Ямар сахиустай байсан бэ?

Дашдорж: Дамдин, шанзлан гээд хоёр сахиус, Их бага хоёр сахиус.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

2

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Энэ хийдийн лам нар аль овоогоо тахидаг байсан бэ?

Дашдорж: Тэр Баярт.

Жужа: Жас хэдэн онд байгуулагдсан бэ, мэдэх үү?

Дашдорж: Тэрийг бол би мэдэхгүй ээ. Намайг хүүхэд байхад л тийм хурал байсан.

Жужа: Тариатын жасын тухай мэдэх үү?

Дашдорж: Мэдэхгүй. Уртнасан аграмба гэж хотын том лам хэдэн шавь нартайгаа ирээд л тийм жас байгуулсан юм гэнэ лээ. Уртнасан аграмба гэж байсан юм.

Жужа: Өөр энэ хавийн хийдийн жасын талаар мэдэх юм байгаа юу? Алтанбулагийн нутагт?

Дашдорж: Бор-Өндөрийн жас гэж байсан. Өөр нэг их байгаагүй байх аа.

Жужа: Бор-Өндөрийн жас хэдэн дугантай хэдэн ламтай байсан бэ?

Дашдорж: Хөдөөнөөс очсон, цугласан лам нар л хурал хурдаг. Ганц хоёр хүн л , цагийнхаа хурлыг цуглаж хурдаг.

Жужа: Хэдэн дугантай байсан бэ?

Дашдорж: 2 дуган байсан.

Жужа: Ямар ямар дуган байсан бэ?

Дашдорж: Модон дуган.

Жужа: Юуны юуны дуган бэ?

Дашдорж: Дамжаагийн дуган...

Жужа: Нөгөө нь, Баяртын жасын 2 дуган юуны дуган байсан бэ?

Дашдорж: Хурал хурдаг л дуган байхгүй юу, магтаал уншдаг.

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно. 3